



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 89

Мандалговь

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Дундговь-Ус” ОНӨҮГ-т хавсралтын дагуу өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 6,881,901 /зургаан сая найман зуун наян нэгэн мянга есөн зуун нэг/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг “Дундговь-Ус” ОНӨҮГ-ын дарга Б.Отгонтөгст даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 сарын 30 өдрийн 89 дугаар тогтоолын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Компьютер /DELL/	1	1,535,200	1,535,200
2	Принтер /CANON MF3010/	1	303,050	303,050
3	Notebook	1	1,224,900	1,224,900
4	2 машины граж	1	3,818,751	3,818,751
Нийт дүн				6,881,901